



ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМ

**БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ**

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН 2024 ОНЫ 03 ДУГААР САРД
ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

СӨҮЛ ХОТ

2024 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын тасаг нь Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд Монгол Улс, БНСУ-ын Хөдөлмөрийн Яам хоорондын “Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох тогтолцоо”-ны дагуу БНСУ-д ажиллах хүч илгээх тухай харилцан ойлголцлын санамж бичиг, ХНХЯ-ны эрхлэх асуудлын хүрээнд ажил олгогч, ажилтан хоёрын хооронд байгуулсан хөдөлмөрийн гэрээнд хяналт тавьж биелэлтийг хангуулах, бусад холбогдох хууль тогтоомжуудыг хэрэгжүүлэн, БНСУ-д ажиллаж амьдарч буй иргэдийнхээ эрх ашгийг хамгаалан ажиллаж байна.

1. АЖИЛЛАХ ХҮЧ ИЛГЭЭХ САНАМЖ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАЖ, ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦААТАЙ ХОЛБООТОЙ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛУУД

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын тасаг нь 2024 оны 03 дугаар сарын 01-нээс 03 дугаар сарын 31-ний өдрийн хооронд хөдөлмөрийн харилцаанд тулгарсан асуудлаа шийдвэрлүүлэхээр танхим, цахим, утас болон факсаар хандсан нийт 266 иргэний санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч, БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам, Үндэсний тэтгэврийн алба болон ажил олгогч эзэд, холбогдох бусад байгууллагуудтай харилцан зөвшилцөх, эвлэрүүлэн зуучлах, гомдол барагдуулах, орчуулга хийх, хууль эрх зүйн зөвлөгөө өгөх зэргээр үйлчилгээ үзүүлэн, өргөдөл гомдлыг шийдвэрлэж ажиллав.

Тус ажлын үр дүнд БНСУ-ын Самсунг даатгалын оршин суух хугацаа дуусгавар болсны даатгал, нутаг буцах зардал, 13 дахь сарын цалин зэрэг нийт 13,919,500 воныг Монгол Улсын иргэдэд олгууллаа.

1.1 Хөдөлмөрийн гэрээт ажилчидтай холбоотой өргөдөл, гомдлын хүрээнд

- Хөдөлмөрийн гэрээт ажилчин Ш.О нь хүндээр өвчилж, бие даах чадваргүй болсон тул эмнэлгийн магадалгаа гаргуулан, асран хамгаалагчийг авчруулсан. Мөн тухайн иргэний асуудлаар ажил олгогчтой тохиролцоонд хүрч чадахгүй байгаа тул эрүүгийн хэрэг үүсгэн ажиллаж байна.

2. НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ХЭЛЭЛЦЭЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАЖ, НИЙГМИЙН ДААТГАЛТАЙ ХОЛБООТОЙ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛУУД

2.1. БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй иргэдийг Монгол Улсын нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалд албан журмаар хамруулах, Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын тэтгэврийн даатгалд даатгуулсан гэрчилгээ бичиж олгох ажлын хүрээнд

Тайлант хугацаанд нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалд 113 иргэнийг шинээр хамруулан “Солонгос улсад гэрээгээр ажиллагсдын программ”-д мэдээллийг бүртгэн гэрээ байгуулав. Нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалд даатгуулсан иргэдэд шинээр 86, гэрээний хугацаа сунгасан 40, ажлын байраа сольсон, гэрчилгээг гээж үрэгдүүлсэн, албан байгууллага нь хүсэлт гаргасан 9 даатгуулагчид Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын тэтгэврийн даатгалд даатгуулсан гэрчилгээг тус тус бичиж олгов.

2.2. БНСУ-д оршин сүүж буй иргэдийг Монгол Улсын нийгмийн даатгалын сайн дурьд даатгалд хамруулах, Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн

газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын тэтгэврийн даатгалд даатгуулсан гэрчилгээ бичиж олгох

Нийт 37 иргэнийг сайн дурын даатгалд шинээр хамруулав. БНСУ-ын ААН-д хөдөлмөр эрхэлдэг 42 даатгуулагчийн хүсэлтийн дагуу Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын тэтгэврийн даатгалд даатгуулсан гэрчилгээг бичиж олгов.

2.3 Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлого төвлөрүүлэх ажлын хүрээнд

НДЕГ-ын даргын 2024 оны А/02 дугаар тушаалаар тус тасгийн 2024 оны орлогын төлөвлөгөө 4,997,799,000.00 төгрөгөөр батлагдсан бөгөөд сар бүрийн орлогын төлөвлөгөө 416,483,250.00 төгрөг болно.

Тус тасаг нь тайлант хугацаанд тэтгэврийн даатгалын шимтгэл 54,929,999.00 вон буюу 139,522,197.46 төгрөг, сайн дурын даатгалын шимтгэл 121,911,632 төгрөгийн шимтгэлийн орлогыг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 63 хувиар биелүүлсэн.

Орлогын төлөвлөгөөний биелэлт 03 дугаар сарын байдлаар харуулбал

Хүснэгт-1
/2024.03.31-ний байдлаар/

Сар	Сарын орлогын төлөвлөгөө /төгрөгөөр/	Тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого		Сайн дурын даатгалын шимтгэлийн орлого	Нийт төвлөрүүлсэн шимтгэлийн орлого		Биелэлтийн хувь	Тухайн сарын МБ-ны эхний даваа гарагийн хаалтын ханш
		Воноор	Төгрөгөөр	Төгрөгөөр	Воноор	Төгрөгөөр		
3	416,483,250.00	54,929,999.00	139,522,197.46	121,911,632.00	54,929,999.00	261,433,829.46	63	2.54

Солонгос улсад гэрээгээр ажиллагсдын программд гэрээний хугацаа, шимтгэл төлөлтийн тооцоог тус тус хянаж ажиллав.

Хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсдын ажил олгогчдод тухайн сарын болон өмнөх саруудын шимтгэл төлөхийг сануулж, 403 ширхэг нэхэмжлэл факсаар илгээн, нийт 682 даатгуулагчтай шимтгэл төлөхийг шаардаж утсаар холбогдов.

2.4. БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр (Е-9, Н-2 оршин суух эрхээр) ажиллах хугацаандаа тус улсын Үндэсний тэтгэврийн даатгалд шимтгэл төлсөн иргэдийн шимтгэлийг буцаан олгуулах ажлын хүрээнд

БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллах хугацаандаа БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалд даатгуулаад нутаг буцсан, төлсөн шимтгэлээ буцааж авахаар хүсэлт ирүүлсэн 202 дугаар ээлжийн 4 иргэний материал НДЕГ-аас ирснийг БНСУ-ын УТА-д хүргүүлэв. Өмнө нь УТА-д илгээсэн 194-201 дүгээр ээлжийн хариуг шийдвэрлүүлэхээр ажиллаж байна. УТА-ны зүгээс ажлын ачаалал их, мөн нэг даатгуулагчийн буцаан олголтыг шийдвэрлэхийн тулд харьяа аймаг, дүүргүүдийн УТА-ны салбаруудаар дамжуулан шалгаж, шийдвэрлэдэг учраас удаашралтай байгаа гэсэн тайлбарыг өгсөн.

3. ТӨВИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН БУСАД АЖЛУУД

3.1 Мэдээлэл, сурталчилгааны ажлын хүрээнд

Төвийн БНСУ дахь “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв” социал хуудсанд 9 удаа, байгууллагын <https://seoulcenter.mlsp.gov.mn> цахим хуудсанд 10 удаагийн мэдээлэл, зөвлөгөө нийтэлж, БНСУ-д амьдарч буй иргэдийн өргөн ашигладаг социал хуудсууд /Нүүдэлчин Монголчууд, Дэлхийн Монголчуудын радио-MGLRADIO, Гэрээнийхэн наашаа E-9, Солонгос дахь Монголчуудын нэгдсэн групп, ХХҮЕГ БНСУ-д хөдөлмөрийн гэрээний ажилтан/-д түгээн сурталчилснаар 47228 орчим хандалт авсан.

Нунсан хотын “Коньган майл” компанийн цехийн дарга Э.Тэмүүжинг хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй иргэдийн сайн жишээгээр сонгож ярилцлага бэлтгэн төвийн вебсайт, пэйж хуудсаар нийтэлж сурталчилсан.

Давхардсан тоогоор 650, үүнээс 633 иргэн, даатгуулагч, ажил олгогчид утсаар, 17 иргэн, даатгуулагчид биечлэн Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр, нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжууд, БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалаас буцаан олголт авах талаар болон бусад төрлийн мэдээлэл, заавар, зөвлөгөө өгч, сурталчилгааны материал тараан ажиллав.

3.2 Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд

Сөүлийн цагдаагийн газрын Монголыг хариуцсан төлөөлөгчтэй албан уулзалт зохион байгуулж, гэмт хэрэг зөрчилд холбогдсон Монгол улсын иргэдэд хууль эрх зүйн туслалцаа үзүүлэх, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлд хамтран ажиллахаар тохиролцсон. Энэ хүрээнд гэмт хэрэг зөрчлөөс сэргийлэх тухай гарын авлагыг цахим болон хэвлэмэл байдлаар хүлээн авч хөдөлмөрийн гэрээт 103 ажилчинд хүргэсэн.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан хөдөлмөрийн гэрээт ажилчдын ажлын байр болон бүс нутгуудад очин санал хүсэлтийг сонсох, хууль бусаар оршин суухын хор уршиг, хугацаандаа нутаг буцах талаар мэдээлэл зөвлөгөө өгөх зорилтын хүрээнд хөдөлмөрийн гэрээт ажилчид олноор ажилладаг аж үйлдвэр төвлөрсөн бүс нутгийн 12 үйлдвэрийн төлөөлөгчидтэй холбогдон очиж ажиллах санал тавьсан. Үүнээс 03 дугаар сарын 11, 15, 16-ны өдрүүдэд БНСУ-ын Пажу, Тэгү, Тэжон, Нунсан, Илсан хотууд дахь 5 үйлдвэрт очиж хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй 42 Монгол Улсын иргэнтэй уулзаж нөхцөл байдалтай нь танилцан, ажил олгогчтой санал солилцож нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж, хөдөлмөрийн харилцаатай холбоотой мэдээлэл, зөвлөмжүүдийг хүргэн гарын авлага тараасан.

Байгууллагын чиг үүрэг, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан зорилтын хүрээнд зорилтот бүлэгт чиглэсэн сургалт зохион байгуулах, хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын тухай хуулийн хүрээнд хууль эрх зүйн мэдээлэл өгөх зорилгоор БНСУ дахь Монгол сургуулийн сурган хүмүүжүүлэгч багш нарт хүүхэд хамгааллын хууль тогтоомж, хүүхдийн сэтгэл зүйн тулгамдсан асуудал, түүнчлэн нийгмийн даатгалын хууль тогтоомжоор сургалт мэдээлэл хүргэж ажиллав.

2024 оны 03 дугаар сарын 21-ний өдөр Илсан хотод шинээр нээлтээ хийж буй “Намү” хүүхэд, гэр бүлийн хөгжлийн төвийн нээлтэд оролцож гэр бүл, хүүхдийн асуудлаар хамтран ажиллахаар ярилцав.

Төвийн хамтран ажиллах гэрээ, санамж бичиг, хэлэлцээр бүхий төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагын жагсаалт, мэдээлэл, хамтын ажиллагааны чиглэл, зорилго, хэрэгжих хугацаа зэргийг нэгтгэн мэдээллийг шинэчилсэн.

Хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн тогтолцооны дагуу БНСУ-д орж ирэн ажиллаад нутаг буцахдаа оршин суух хугацаа дуусгавар болсны даатгал, нутаг буцах замын зардлын даатгал зэргээ авч чадаагүй явсан иргэдэд авч чадаагүй даатгалын олговрыг буцаан олгуулах ажлын хүрээнд ХХҮЕГ-т албан бичиг төлөвлөн хүргүүлэв.

НДЕГ-аас шинээр нэвтрүүлж буй нийгмийн даатгалын программд тасгийн программын шинэчлэлтийг нэвтрүүлж, программыг идэвхжүүлэхээр НДЕГ-ын холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж 4 сардаа багтаан программыг нэвтрүүлэхээр ажиллаж байна.

3.3 Сургалт, судалгааны ажлын хүрээнд

БНСУ-д 2024 оны 03 дугаар сард хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар ирэх 24 иргэнд ирэхээс өмнөх сургалтыг 2024 оны 03 дугаар сарын 18-ны өдөр цахимаар, БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлтийн хөгжлийн сангийн Ёжү хот дахь Олон улсын сургалтын төвд 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдөр ирсний дараах сургалтыг танхимаар зохион байгуулж 88 гэрээт иргэнийг хамруулан дараах агуулгын хүрээнд мэдээлэл өгөв. Үүнд:

- ХНХҮТ-ийн үйл ажиллагааны товч танилцуулга
- Солонгос улсын хууль, дүрэм, журам
- Монгол иргэдийн гэмт хэрэгт холбогдож буй байдал
- Үйлдвэрлэлийн осол, үйлдвэрлэлийн ослын даатгал, ХАБЭ, ослоос урьдчилан сэргийлэх
- Суугаа орондоо дасан зохицоход анхаарах зүйл
- Ур чадвартай ажиллах хүч E7 визний талаар
- Хууль бусаар оршин суухын сөрөг тал, хуулийн дагуу оршин суухын давуу талуудын талаар.

Сургалтад хамрагдсан 10 гэрээт иргэнд сургалтын материалыг и-мэйлээр илгээсэн.

Хангүг их сургуулийн судлаач багш Шин Мин Сон, Мөнхнасан нарын хүсэлтээр албан уулзалт хийж, гэрээт иргэдээс авах судалгааны ажилд хамтран ажиллах, судалгааны үр дүнг хуваалцахаар тохиролцов.

Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх богино болон дунд хугацааны сургалтын агуулгаас албан хаагчдын сургалтын хэрэгцээг тодорхойлон Удирдлагын академитай хамтран ажиллахаар холбогдсон.

3.4 Бусад дотоод ажлын хүрээнд

- Байгууллагын дотоод хяналтын жилийн ажлын төлөвлөгөөнд тусгасны дагуу тайлант хугацаанд шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, өргөдөл гомдлын шийдвэрлэлт, төвийн өмч хөрөнгийн хадгалалт, бүртгэл, ашиглалт, зарцуулалтад тус тус дотоод хяналт хэрэгжүүлж, дүгнэлт зөвлөмж гаргасан.
- Төвийн өглөг авлагын байдалд тогтмол хяналт тавьж, авлагын насжилт, эргэн төлөлтийн судалгааг 2 удаа шинэчлэн гаргаж, 6 удаа албан бичиг, мэдэгдлийг хариуцагчид илгээн, авлагыг барагдуулах чиглэлд шат дараатай арга хэмжээ хэрэгжүүлснээр 1,200,000 воныг байгууллагын дансанд төвлөрүүлсэн.
- ХХҮЕГ-ын улсын байцаагчийн нөхөн төлүүлэхээр шийдвэрлэсэн актыг барагдуулах чиглэлээр хариуцагчдад 3 мэдэгдэл хүргүүлсэн.

- Хамтран ажиллах, хариу хүргүүлэх тухай 24 албан бичиг илгээж, иргэнээс 7 өргөдөл, байгууллагаас 3 албан бичиг ирүүлснийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн.
- Нийгмийн даатгалын санд төвлөрүүлсэн 3 дугаар сарын шимтгэлийн орлогыг НДЕГ-ын Төрийн сан дахь холбогдох дансанд шилжүүлэн, тайлан мэдээг Санхүү бүртгэлийн газарт хүргүүлсэн.
- Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасан болзол нөхцөлийг хангасан, тэтгэмж авах эрх үүссэн 2 даатгуулагчид зохих журмын дагуу даатгуулагчийн тодорхойлолтыг гаргаж, шаардлагатай бичиг баримтыг монгол хэл рүү хөрвүүлж өгсөн. Мөн Нийгмийн даатгалын аппликейшнд шинээр 2 иргэний бүртгэлийг баталгаажуулав.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын тасгийн сар тутмын тоон мэдээ

/2024 оны 01 дүгээр сар/

№	Агуулга	Дүн
1	Иргэдэд олгуулсан мөнгөн дүн	13,919,500
2	Шийдвэрлэсэн өргөдөл, гомдол	266